Тайлант оны батлагдсан төсвийг 10 хувиар хэмнэж ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудитаар нийт 697,064.2 мянган төгрөгийн 16 алдаа, зөрчил илрүүлснээс 448.0 мянган төгрөгийг залруулж, өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд 21 мэдээг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд 1 албан шаардлагын биелүүлээгүй, 9,147.1

мянган төгрөгийн 2 төлбөрийн актыг 100 хувь барагдуулж, 85,157.7 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	-	-	1	-	-
Төлбөрийн акт	2	9,147.1	2	9,147.1	-	-	100
Зөвлөмж	3	85,157.7	3	85,157.7	-	-	100
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>94,304.8</b>	<b>5</b>	<b>94,304.8</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>83.3</b>

Шилэн дансны цахим хуудсанд 18 мэдээг хугацаа хоцроож байршуулсан, зарлагын 3 удаагийн 46,622.2 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулаагүй;

Аймаг, хот, сумдад ажилласан 15 ажилтанд нийт 1,752.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг томилолтын хуудасгүйгээр олгосон зөрчилд, 2 албан шаардлагын биелүүлээгүй, давтан гаргасан зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага өгөх.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн хэмжээнд хэрэгжиж дууссан төсөл, хөтөлбөрүүдийг, шинжлэх ухаан технологийн сангийн итгэмжлэгдсэн хадгалагчид хүлээлгэн өгсөн байдал, орон нутаг дахь салбар хүрээлэнгүүдийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, бүртгэл тайлагналыг авч үзнэ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 523,924.8 мянган төгрөгийн 17 алдаа, зөрчил илэрснээс 228,515.7 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, 25,952.3 мянган төгрөгийн 5 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 220,182.8 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 49,274.0 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 295,408.9 мянган төгрөгийн алдаа, зөрчлийн дүн тогтоосон материаллаг байдал 16,695.0 мянган төгрөгөөс 278,713.9 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай санал дүгнэлт өглөө.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Төслийн 2 гэрээт ажлын 4,480.0 мянган төгрөгөөс 448.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгаагүй;
- "Увс Эм Жи Эл Транс" ХХК-аас авах 1,064.7 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй;
- Тайлант хугацаанд 12 иргэний 30,818.4 мянган төгрөг, 64 байгууллагын 136,796.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг төлбөрийн И баримтгүй;
- Тайлант хугацаанд 580,801.5 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 40 нэр төрлийн хөрөнгөнд 11,780.7 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланг 46,542.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангаарх төвлөрүүлэх шилжүүлгийн дүн мөнгөн хөрөнгийн журналын дүнгээс 1,064.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

##### 4.2 Төлбөрийн акт

Шатахуун зарцуулалтын жишиг нормыг илүү тооцсоноос 2,789.7 мянган төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ.", Зам тээвэр хөгжлийн сайдын 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байх, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Аймаг, хот, сумдад албан томилолтоор ажилласан ажилтнуудад

- Хоол, унааны зардлыг давхардуулан 6,275,500.00 төгрөг
- Томилолтын зардал илүү 96,000.00 төгрөг
- Томилолтын хуудасгүй 1,752,000.00 төгрөгийг тус тус олгосон байна.

Эдгээр нь дараах хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байх, батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 24.6 "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ.",
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.2 "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ", 2.2.1 "унааны зардал", 2.2.2 "байрны зардал" 2.2.3 "хоолны зардал", 2.4 "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт

тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно." гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байх, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

- Ажилтны албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг гүйцэтгүүлэхдээ ажил хавсарсны 10-40 хувийн нэмэгдлийг давхардуулан 3 ажилтанд 4,765,562.00 төгрөг;
- Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээнд заагаагүй, тушаал шийдвэргүйгээр 26 ажилтанд илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлсийг 2 дахин нэмэгдүүлэн тооцож 9,172,754.81 төгрөг;
- Захирлын тушаалаар мэргэшлийн зэргийн нэмэгдлийг олгохдоо Эрдэм шинжилгээний дэд ажилтны мэргэшлийн нэмэгдэлтэй давхардуулан 2 ажилтанд 1,100,618.00 төгрөг нийт 15,038,934.81 төгрөгийг тус тус илүү олгосон байна.

Энэ нь дараах хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байх, батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 "Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно.", 53.1 "Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүнд 1.5 дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс олгоно", 53.2 "Энэ хуулийн 53.1 зааснаар олгох нэмэгдүүлсэн цалин хөлсийг хамтын ба хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна",
- Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Улсын төсвөөс санхүүждэг эрдэм шинжилгээний байгууллагын ажилтны цалингийн сүлжээ, тэдгээрт нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгох журмыг Засгийн газар батална",
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт 2.2 "Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол илүү цагийн хөлсийг тодорхойлохдоо сарын цалин хөлсний хэмжээг тухайн сарын ажиллавал зохих цагт хувааж, нэг цагт ногдох цалин хөлсийг тооцож гаргана. Нэг цагийн цалин хөлсийг илүү ажилласан цагаар үржүүлж гарсан цагийг 1.5 (1.5 ба түүнээс дээш байхыг хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээнд тусгаж зохицуулна) дахин нэмэгдүүлж, илүү цагийн хөлсний хэмжээг тодорхойлно.", 5 дугаар хавсралт Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журмын 6 дугаар заалт "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдлийг зөвхөн тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа хугацаанд нь олгоно".

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

#### 4.3 Албан шаардлага

- Ажил гүйлгээний нийт 80,185,748.00 төгрөгийг өглөгийн дансаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэсэн,
- 2 харилцагчийн 8,764,650.48 төгрөгийн авлага, 5 байгууллагын 131,232,374.05 төгрөгийн өглөг, нийт 220,182,772.53 төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.2 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө.", 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч,

худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **Санхүүгийн тайлантай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Салбар хүрээлэнгүүдийн нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан 19 гүйлгээний 21,181.6 мянган төгрөгийн анхан шатны баримтыг аудитын хугацаанд ирүүлээгүй.

###### Өгсөн зөвлөмж:

*Аудитад салбар хүрээлэнгийн анхан шатны баримтуудыг бүрэн хамруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх аудитад.*

##### **Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 412 нэр төрлийн нийт 1,349,159.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй.

###### Өгсөн зөвлөмж:

*Эрх бүхий байгууллагаар хөрөнгийг дахин үнэлүүлэх, үр дүнг санхүүгийн тайланд үнэн зөв тусгах.*

##### **Цалин хөлстэй холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Ажилчдын цалинг давтан тооцоолоход нийт 71 албан хаагчид 308.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын хөнгөлөлт дутуу тооцсон.

###### Өгсөн зөвлөмж:

*Жилийн эцсийн цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын тайланд ажилтан тус бүрээр үнэн зөв тооцоо бодох, зөрчлийг давтан гаргахгүй байх*

###### Илрүүлэлт:

Байгууллагын жилийн цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг, татварын цахим тайланд илгээсэн ХХОАТ-ын тайлангаас 25,067.4 мянган төгрөгөөр, Нийгмийн даатгалын тайлангаас 2,716.9 мянган төгрөгөөр, нийт 27,784.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

###### Өгсөн зөвлөмж:

*Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын тайлан, Нийгмийн даатгалын тайлан, дэлгэрэнгүй бүртгэлийг тулгаж, үнэн зөв тайлагнах, зөрчлийг давтан гаргахгүй байх.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Д/Д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
					Тоо	Дүн	Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар</b>																
1	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Төслийн 2 гэрээт ажлын 4,480.0 мянган төгрөгөөс 448.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгаагүй байна.	Залруулсан	1	448.0	1	448.0	-	-	-	-	-	-	-	-
2	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	"Увс Эм Жи Эл Транс" ХХК-аас авах 1,064.7 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй.	Залруулсан	1	1,064.7	1	1,064.7	-	-	-	-	-	-	-	-
3	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад Тайлант хугацаанд 12 иргэний 30,818,357.00 төгрөг, 64 байгууллагын 136,796,467.00 төгрөгийн ажил гүйлгээг төлбөрийн И баримт, нэхэмжлэхгүйгээр байна.	Залруулсан	1	167,614.8	1	167,614.8	-	-	-	-	-	-	-	-



Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд 580,801.5 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 40 нэр төрлийн хөрөнгөнд 11,780.7 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй байна.	Залруулсан	1	11,780.7	1	11,780.7	-	-	-	-	-	-	-
5	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн тайланг 46,542.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	Залруулсан	1	46,542.8	1	46,542.8	-	-	-	-	-	-	-
6	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангаарх төвлөрүүлэх шилжүүлгийн дүн мөнгөн хөрөнгийн журналын дүнгээс 1,064.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	Залруулсан	1	1,064.7	1	1,064.7							
7	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Шатахуун зарцуулалтын жишиг нормыг илүү тооцоноос 2,789.7 мянган төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан.	Төлбөрийн акт тогтоох	1	2,789.7	-	-	1	2,789.7	-	-	-	-	-
8	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Аймаг, хот, сумдад албан томиллолтоор ажилласан ажилтнуудад албан томиллолтоор ажилласан хугацаанд 6,275.5 мянган төгрөгийн хоол, унаа давхардуулан , 96.0 мянган төгрөгийн томилолтын зардал илүү, илүү, 1,752.0	Төлбөрийн акт тогтоох	1	8,123.5	-	-	1	8,123.5	-	-	-	-	-

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			мянган төгрөгийг томилолтын хуудасгүй тус тус олгосон байна.																	
9	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Ажилтны ажлын чиг үүрэгт заагдсан ажилд, ажил хавсарсны 10-40 хувийн нэмэгдлийг давхардуулан с 3 ажилтанд 4,765.5 мянган төгрөгийн нэмэгдлийг илүү олгосон	Төлбөрийн акт тогтоох	1	4,765.5	-	-	1	4,765.5	-	-	-	-	-	-	-	-	-	-
10	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Нийт 26 ажилтанд илүү цагийн нэмэгдлийг хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээнд заагаагүй, тушаал шийдвэргүйгээр, 1 цагийн цалин хөлсийг 2 дахин нэмэгдүүлэн тооцож 9,172.7 мянган төгрөгийг олгосон.	Төлбөрийн акт тогтоох	1	9,172.7	-	-	1	9,172.7	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Нийт 2 ажилтанд Захирлын 26 дугаар тушаалаар мэргэшлийн зэргийн нэмэгдлийг олгохдоо Эрдэм шинжилгээний дэд ажилтны мэргэшлийн нэмэгдэлтэй давхардуулан 1,100.6 мянган төгрөгийг олгосон.	Төлбөрийн акт тогтоох	1	1,100.6	-	-	1	1,100.6	-	-	-	-	-	-	-	-	-	-
12	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Ажил гүйлгээний нийт 80,185.7 мянган төгрөгийг өглөгийн дансаар дамжуулаагүй шууд зардлын дансанд бүртгэж тайлагнасан.	Албан шаардлага өгөх	1	80,185.8	-	-	-	-	1	80,185.8	-	-	-	-	-	-	-	-

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

13	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Нийт 2 харилцагчийн 8,764.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл, 5 байгууллагын 131,232.4 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	Албан шаардлага өгөх	1	139,997.0	-	-	-	-	1	139,997.0	-	-	-
14	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Салбар хүрээлэнгүүдийн нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан 19 гүйлгээний 21,181.6 мянган төгрөгийн анхан шатны баримтыг аудитын хугацаанд ирүүлээгүй.	Зөвлөмж өгөх	1	21,181.6	-	-	-	-	-	-	-	1	21,181.6
15	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Байгууллагын жилийн цалин хөлсийн дэлгэрэнгүй бүртгэлийг, татварын цахим тайланд илгээсэн ХХОАТ-ын тайлангаас 25,067.4 мянган төгрөгөөр, Нийгмийн даатгалын тайлангаас 2,716.9 мянган төгрөгөөр, нийт 27,784.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	Зөвлөмж өгөх	1	-	-	-	-	-	-	-	-	1	27,784.4
16	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Ажилчдын цалинг давтан тооцоолоход нийт 71 албан хаагчид 308.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын хөнгөлөлт дутуу тооцсон.	Зөвлөмж өгөх	1	308.0	-	-	-	-	-	-	-	1	308.0

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

17	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 412 нэр төрлийн нийт 1,349,159.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй.	Зөвлөмж өгөх	1	27,784.4								1	-	
<b>Дүн</b>					<b>17</b>	<b>523,924.5</b>	<b>6</b>	<b>228,515.7</b>	<b>5</b>	<b>25,952.0</b>	<b>2</b>	<b>220,182.8</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>49,274.0</b>
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>																
1	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг шалгахад нийт 175 мэдээлэл байршуулахаас 157 мэдээлэл хугацаанд нь, 18 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан. Байгууллагын батлагдсан төсвийн мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2 удаагийн зарлагын 3 удаагийн 46,622.2 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулаагүй байна.	Хариуцлага тооцох албан шаардлага өгөх	1	46,622.2	-	-	-	-	1	46,622.2	1	46,622.2	-	-
2	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2020/62-НА-СТА-ТШЗ	Тайлант оны батлагдсан төсвийг 10 хувиар хэмнэж ажиллаагүй байна.	Албан шаардлага өгөх	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
<b>Дүн</b>					<b>2</b>	<b>46,622.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>46,622.2</b>	<b>1</b>	<b>46,622.2</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>НИЙТ ДҮН</b>					<b>19</b>	<b>570,546.7</b>	<b>6</b>	<b>228,515.7</b>	<b>5</b>	<b>25,952.0</b>	<b>4</b>	<b>266,805.0</b>	<b>1</b>	<b>46,622.2</b>	<b>4</b>	<b>49,274.0</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 71/20150058  
АХГ-0029/62/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Ажилтны албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг гүйцэтгүүлэхдээ ажил хавсарсны 10-40 хувийн нэмэгдлийг давхардуулан 3 ажилтанд 4,765,562.00 төгрөг;
- Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээнд заагаагүй, тушаал шийдвэргүйгээр 26 ажилтанд илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлсийг 2 дахин нэмэгдүүлэн тооцож 9,172,754.81 төгрөг;
- Захирлын тушаалаар мэргэшлийн зэргийн нэмэгдлийг олгохдоо Эрдэм шинжилгээний дэд ажилтны мэргэшлийн нэмэгдэлтэй давхардуулан 2 ажилтанд 1,100,618.00 төгрөг нийт 15,038,934.81 төгрөгийг тус тус илүү олгосон байна.

Энэ нь дараах хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байх, батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 "Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно.", 53.1 "Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүнд 1.5 дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс олгоно", 53.2 "Энэ хуулийн 53.1 зааснаар олгох нэмэгдүүлсэн цалин хөлсийг хамтын ба хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна",
- Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Улсын төсвөөс санхүүждэг эрдэм шинжилгээний байгууллагын ажилтны цалингийн сүлжээ, тэдгээрт нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгох журмыг Засгийн газар батална",
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт 2.2 "Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол илүү цагийн хөлсийг тодорхойлохдоо сарын цалин хөлсний хэмжээг тухайн сарын ажиллавал зохих цагт хувааж, нэг цагт ногдох цалин хөлсийг тооцож гаргана. Нэг цагийн цалин хөлсийг илүү ажилласан цагаар үржүүлж гарсан цагийг 1.5 (1.5 ба түүнээс дээш байхыг хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээнд тусгаж зохицуулна) дахин нэмэгдүүлж, илүү цагийн хөлсний хэмжээг тодорхойлно.", 5 дугаар хавсралт Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журмын 6 дугаар заалт "Хуульд өөрөөр заагаагүй бол

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Akt\2022\0315 Auditin 4 Газар-8.Docx


001090213

төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдлийг зөвхөн тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа хугацаанд нь олгоно".

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3 заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 15,038,934.81 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Т.Батсүх, Ерөнхий нягтлан бодогч Г.Өсөхжаргал нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**  
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Г.АРИУНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 70/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/62/МА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Аймаг, хот, сумдад албан томилолтоор ажилласан ажилтнуудад

- Хоол, унааны зардлыг давхардуулан 6,275,500.00 төгрөг
- Томилолтын зардал илүү 96,000.00 төгрөг
- Томилолтын хуудасгүй 1,752,000.00 төгрөгийг тус тус олгосон байна.

Эдгээр нь дараах хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байх, батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 24.6 "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ.",
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.2 "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ", 2.2.1 "унааны зардал", 2.2.2 "байрны зардал" 2.2.3 "хоолны зардал", 2.4 "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно." гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байх, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3 заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Томилолтоор явсан ажилчдад хоол, унааны мөнгө давхардуулан, томилолтын зардлыг илүү тооцож олгосон 8,123,500.00 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Т.Батсүх, Ерөнхий нягтлан бодогч Г.Өсөхжаргал нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Г.АРИУНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 63/20150058  
АХГ-2022/62/МА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шатахууны зарцуулалтын жишиг нормыг илүү тооцсоноос 2,789,705.00 төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ.", Зам тээвэр хөгжлийн сайдын 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байх, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3 заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Шатахуун хэтрүүлэн зарцуулсан 2,789,705.00 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Т.Батсүх, Ерөнхий нягтлан бодогч Г.Өсөхжаргал нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХАК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Г.АРИУНБАТ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 382/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/62/МА-СТА-ГМЗ

Сахилгын шийтгэл хүлээлгэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 18 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2 удаагийн, зарлагын 3 удаагийн 46,622,200.00 төгрөгийн мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2 заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2 Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2 заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өмнөх аудитын шилэн данстай холбоотой өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй Ерөнхий нягтлан бодогч Г.Өсөжаргалд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Т.Батсүхэд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Г.АРИУНБАТ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 381/20220058

Улаанбаатар хот

АХГ-2022/00/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд, заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны батлагдсан төсвийг 10 хувиар хэмнэж ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах," гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөв захирагч нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Т.Батсүх, Ерөнхий нягтлан бодогч Г.Өсөхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Г.АРИУНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 380/АД/СООС

Улаанбаатар хот

АХГ-2022/62/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Ажил, гүйлгээний нийт 80,185,748.00 төгрөгийг өглөгийн дансаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэсэн,
- 2 харилцагчийн 8,764,650.48 төгрөгийн авлага, 5 байгууллагын 131,232,374.05 төгрөгийн өглөг, нийт 220,182,772.53 төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.2 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө.", 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулж байх, авлага өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Т.Батсүх, Ерөнхий нягтлан бодогч Г.Өсөхжаргал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Г.АРИУНБАТ

0010801083



